



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Жавхлант сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2024/06-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.open.audit.mn Сүхбаатар сум 2024 он	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn Аудитор: О.Анхбаяр Утас: 7036-2442 Цахим хаяг: ankhbayaro@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.АУДИТЫН ДҮГНЭЛТ.....	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	9
3.4.1 Мөнгөн хөрөнгө.....	11
3.4.2 Авлага	12
3.4.3 Бараа материал.....	12
3.4.4 Үндсэн хөрөнгө	12
3.4.5 Өр төлбөр.....	13
3.4.6 Засгийн газрын хувь оролцоо	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	19
4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	19
4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	19
4.6.1 Завсрын аудитын талаар.....	19
4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	19
4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	20
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.1 Төлбөрийн акт.....	20
5.2 Албан шаардлага	21
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТБОНӨБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ЖАВХЛАНТ СУМЫН ЗАСАГ
ДАРГА Ц.ДАРХАНБААТАР ТАНАА

2024.03.28 № 00А-2024/06-НА-СТА-ТТЗ
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан зөрчил нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Сэлэнгэ аймгийн Жавхланта сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон 11,425.4 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс өндөр бөгөөд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, 57 дугаар зүйлийн 57.2, 57.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.5-д заасантай болон Сангийн сайдын Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал”, 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”- тай тус тус нийцээгүй байна

Асуудлыг онцолсон хэсэг

018020442⁴

Сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолоор 406,872.0 мянган төгрөгийн татварын орлого, 37,235.9 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 431,275.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 2.9 хувиар тасалсан байна.

Аудитын гол асуудал

Аймгийн төсвөөс төвлөрүүлэхээр төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг 103,284.5 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэн, сумын төсвийн орлогын төлөвлөгөө 12,832.4 мянган төгрөгөөр тасарсан зэргээс шалтгаалж, ЗДТГ-ын халаалтын зардалд **13,775.5** мянган төгрөгийн өр төлбөр үүссэн байна.

Бусад асуудлын хэсэг

Жавхлант сумын Засаг дарга нь тайлант онд 16 зорилт, 125 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 97.1 хувийн биелэлттэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	369,128.5	340,082.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	200,713.5	207,245.8
33	АВЛАГА	120,306.4	102,202.2
35	БАРАА МАТЕРИАЛ	28,986.6	30,634.7
36	НӨӨЦИЙН БАРАА	19,122.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,591,455.0	1,665,650.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,591,455.0	1,665,650.6
39200	Биет хөрөнгө	1,587,367.8	1,661,664.7
39300	Биет бус хөрөнгө	4,087.2	3,985.9
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	1,960,583.5	2,005,733.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.0	14,682.3
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.0	14,682.3
41300	Өглөг	0.0	14,682.3
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	1,960,583.5	1,991,051.0
51	Засгийн газрын хувь оролцоо	1,960,583.5	1,991,051.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	339,508.6	339,508.6
51200	Хуримтлагдсан үр дүн	1,379,778.1	1,410,245.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	241,296.8	241,296.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	1,960,583.5	2,005,733.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,904,216.8	1,769,325.7
11	ТАТВАРЫН ОРЛОГО	310,057.5	380,455.9
110	Орлогын албан татвар	146,919.3	194,440.7
1100	Хувь хүний орлогын албан татвар	146,919.3	216,518.5
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0.0	-22,077.8
113	Хөрөнгийн албан татвар	88,212.8	128,259.6
118	Бусад татвар, төлбөр, хураамж	74,925.4	57,755.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	227,499.4	308,641.4
120	Нийтлэг татварын бус орлого	227,499.4	308,641.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,366,659.9	1,080,228.4
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,142,537.7	1,457,806.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,142,537.7	1,457,806.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,123,976.5	1,410,534.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,243.6	461,328.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	42,298.0	57,747.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	368,835.0	74,352.1
2104	Хангамж, бараа материалын зардал	40,876.7	42,221.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,737.3	12,319.2
2107	Томилолт, зочны зардал	3,834.8	4,118.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,175.4	379,885.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	255,975.7	378,562.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	18,561.2	47,272.2
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	761,679.1	311,519.1
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	2,884,590.3	281,051.6

VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	-2,122,911.2	30,467.5
----	---	--------------	----------

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,085,839.00	4,085,839.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-2,344.30	-2,344.30
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,083,494.60	4,083,494.60
9	Тайлант үеийн үр дүн	-2,122,911.20	-2,122,911.20
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,960,583.50	1,960,583.50
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,960,583.50	1,960,583.50
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,960,583.50	1,960,583.50
19	Тайлант үеийн үр дүн	30,467.50	30,467.50
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,991,051.00	1,991,051.00

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,728,728.40	1,543,754.60
11	ТАТВАРЫН ОРЛОГО	310,057.50	380,455.90
110	Орлогын албан татвар	146,919.30	194,440.70
1100	Хувь хүний орлогын албан татвар	146,919.30	216,518.50
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-22,077.80
113	Хөрөнгийн албан татвар	88,212.80	128,259.60
118	Бусад татвар, төлбөр, хураамж	74,925.40	57,755.50
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	4,723.10	3,909.70
1181	Газрын төлбөр	65,971.40	40,606.90
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	4,231.00	13,238.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	52,011.00	83,070.30
120	Нийтлэг татварын бус орлого	52,011.00	83,070.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,366,659.90	1,080,228.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	962,399.00	1,204,038.50
21	УРСГАЛ ЗАРДАЛ	962,399.00	1,204,038.50
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	943,837.80	1,156,766.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	349,666.20	460,236.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	43,175.80	57,523.40
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	368,835.00	60,576.60
2104	Хангамж, бараа материалын зардал	38,271.50	37,994.30
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,783.90	13,089.20
2107	Томилолт, зочны зардал	3,834.80	4,118.40
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,175.40	381,639.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,095.20	141,588.30
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	976,363.80	47,272.20
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	766,329.40	339,716.10
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	639,858.40	298,183.80
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	639,858.40	298,183.80
2200	Дотоод эх үүсвэрээр	639,858.40	298,183.80
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-639,858.40	-298,183.80

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-30,000.00	-35,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	30,000.00	35,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	96,471.00	6,532.30
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	104,242.50	200,713.50
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	200,713.50	207,245.80

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Хэтрэлт /хэмнэлт	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,840,831.9	1,493,073.7	-347,758.2	81.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,226,221.5	1,177,022.1	-49,199.4	96.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,179,034.4	1,129,839.9	-49,194.5	95.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	482,005.3	460,236.5	-21,768.8	95.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	61,550.8	57,523.4	-4,027.4	93.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	414,176.7	393,501.7	-20,675.0	95.0
2104	Хангамж, бараа материалын зардал	38,111.8	37,838.5	-273.3	99.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,488.2	57,404.8	-83.4	99.9
2107	Томилолт, зочны зардал	4,232.4	4,118.4	-114.0	97.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,645.5	4,873.4	-1,772.1	73.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	114,823.7	114,343.2	-480.5	99.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,187.1	47,182.2	-4.9	100.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	47,187.1	47,182.2	-4.9	100.0
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	494,610.4	281,051.6	-213,558.8	56.8
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,000.0	35,000.0	-85,000.0	29.2
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,840,831.9	1,611,720.6	-229,111.3	87.6
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	0.0	0.0	0.0	0.0
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,554,090.0	1,557,392.0	3,302.0	100.2
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	286,741.9	54,328.6	-232,413.3	18.9
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.0	82,969.4	82,969.4	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.0	201,616.3	201,616.3	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	52.0	50.0	-2.0	96.2
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.0	2.0	0.0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	25.0	24.0	-1.0	96.0
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.0	24.0	-1.0	96.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код:	Тайлангийн үзүүлэлт	Тайлант оны гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	45,455.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	42,310.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	40,913.7

2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,594.0
2104	Хангамж, бараа материалын зардал	343.2
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,481.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	250.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,245.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,396.7
2132	Бусад урсгал шилжүүлэг	90.0
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	1,306.7
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,144.9
2200	Дотоод эх үүсвэр	3,144.9
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	45,455.3
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	45,455.3
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	0.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Жавхлант сумын ТТЗ-ийн үйл ажиллагааны эрхэм зорилгыг “Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх, боловсон хүчний мэдлэг чадварыг дээшлүүлж, мэргэшсэн тогтвортой, ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх.” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,

- Нутаг дэвсгэрийнхээ татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах;

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,*
- *Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад 2023 оны 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,*
- *Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд өөрчлөлт орсон,*
- *Төрийн албаны тухай хуульд 2023 оны 01 дүгээр сарын 06, 05 дугаар сарын 04, 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07, 11 дүгээр сарын 10, 12 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,*
- *Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн зарим албан хаагчийн цалингийн сүлжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

2023 онд тус ТТЗ-ийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дотоод хяналт, шалгалт хийгдээгүй боловч ЗДТГ-ын СТСХ-ээс төсвийн гүйцэтгэлийн тайлан, мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт шалгалт хийгдсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жавхлант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Жавхлант сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар батлагдсан “Аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт

байгууллагуудад мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”- ийг нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Жавхлант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 45,149.8 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	200,713.5	207,245.8	6,532.3
Авлага	120,306.4	102,202.2	-18,104.2
Бараа материал	48,108.6	30,634.7	-17,473.9
Үндсэн хөрөнгө	1,591,455.0	1,665,650.6	74,195.6
Нийт хөрөнгө	1,960,583.5	2,005,733.3	45,149.8
Өр төлбөр	0.0	14,682.3	14,682.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,960,583.5	1,991,051.0	30,467.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,960,583.5	2,005,733.3	45,149.8

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо данснуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсныг тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 207,245.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,532.3 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	200,713.5	207,245.8	6,532.3
Төгрөг	200,713.5	207,245.8	6,532.3
Төрийн сангийн харилцах	200,713.5	207,245.8	6,532.3
Дүн	200,713.5	207,245.8	6,532.3

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлд орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 5,629.5 мянган төгрөг, ОНХС-ийн үлдэгдэл 116,014.9 мянган төгрөг, Хоршоог хөгжүүлэх сангийн үлдэгдэл 85,601.4 мянган төгрөг тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 102,202.2 мянган төгрөг болж, өмнөх оноос 18,104.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон авлага	192.2	0.0	-192.2
Зээлийн хүүгийн авлага	5,118.8	4,750.2	-368.6
Байгууллагаас авах авлага	968.2		-968.2
Хувь хүмүүсээс авах авлага	2,293.4	2,293.4	0.0
Хувь хүмүүст олгосон зээл	111,733.8	95,158.6	-16,575.2
Дүн	120,306.4	102,202.2	-18,104.2

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны нийт авлагын үлдэгдлийн 97.7 хувь буюу 99,908.8 мянган төгрөгийг Хоршоог хөгжүүлэх сангийн зээл, хүүгийн авлагын үлдэгдэл эзэлж байна. Үүнээс 30,324.1 мянган төгрөг буюу 30.3 хувь нь 2011-2019 оны хооронд олгосон хугацаа хэтэрсэн зээлийн авлага байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 30,634.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 17,474.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	7,529.4	6,594.3	-935.1
Тусгай зориулалттай материал	7,529.4	6,594.3	-935.1
Эм боох материал	0.0	0.0	0.0
Хангамжийн материал	21,457.3	24,040.4	2,583.1
Бичиг хэргийн материал	2,376.7	2,323.7	-53.0
Аж ахуйн материал	17,843.2	13,959.3	-3,883.9
Сэлбэг хэрэгсэл	324.0	4,114.0	3,790.0
Түлш, шатах тослох материал	0.0	0.0	0.0
Хүнсний материал	0.0	0.0	0.0
Бусад хангамжийн материал	913.4	3,643.4	2,730.0
Мал амьтад	0.0	0.0	0.0
Нөөцийн бараа	19,122.0	0.0	-19,122.0
Дүн	48,108.7	30,634.7	-17,474.0

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл өмнөх оноос 17,474.0 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 395,423.7 мянган төгрөгийн бараа материал худалдан авсан болон 127,969.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 281,891.6 мянган төгрөгийг шилжүүлэн, 3,036.5 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 1,665,650.6 мянган төгрөг болж,

өмнөх оноос 74,195.6 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	1,587,367.8	1,661,664.7	74,296.9
Барилга, байгууламж, орон сууц	492,758.0	493,806.6	1,048.6
Авто-тээврийн хэрэгсэл	12,214.7	102,715.1	90,500.4
Машин тоног төхөөрөмж(компьютер)	52,409.3	46,046.2	-6,363.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	19,607.5	18,466.7	-1,140.8
Дуусаагүй барилга байгууламж	0.0	0.0	0.0
Номын фонд	0.0	0.0	0.0
Бусад үндсэн хөрөнгө	1,010,378.3	1,000,630.1	-9,748.2
Биет бус хөрөнгө	4,087.2	3,985.9	-101.3
Программ хангамж	1,098.2	996.9	-101.3
Бусад биет бус хөрөнгө	2,989.0	2,989.0	0.0
Дүн	1,591,455.0	1,665,650.6	74,195.6

Эх сурвалж: Жавхланта сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 74,195.6 мянган төгрөгөөр өссөн нь дараах ажил, гүйлгээнээс голлон шалтгаалсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгөөр 17,132.2 мянган төгрөгийн хөрөнгө /8,799.9 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2,800.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 5,532.3 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө/ худалдан авсан,
- Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 20,000.0 мянган төгрөгийн хөрөнгийг барилга байгууламж, 97,900.0 мянган төгрөгийг тээврийн хэрэгсэл, 143,816.5 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгийг орлогод авсан.
- БОАЖГ-аас 9,040.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө орлогод авсан,
- АЗДТГ-аас 9,798.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 6,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл орлогод авсан,
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2023 оны 11 сарын 23-ны өдрийн 604 дүгээр тогтоолоор Багануур дүүргийн “Цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-аас 68,000,000 /жаран найман сая/ төгрөгийн өртөг бүхий LEXUS 470 маркийн автомашиныг шилжүүлж авсан,
- ЗДТГ-аас 6,904.8 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 2,220.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил зэрэг нийт 9,125.6 мянган төгрөгийн хөрөнгийг акталж данснаас хассан зэргээс шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөр жилийн эцэст 14,682.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажилчидтай холбогдсон өглөг	0.0	155.0	155.0
Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.0	13,775.5	13,775.5
Байгууллагад төлөх өглөг	0.0	751.8	751.8
Дүн	0.0	14,682.3	14,682.3

Эх сурвалж: Жавхланта сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант оны эцэст өр төлбөр данс үлдэгдэл нь 14,682.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь аймгаас авах санхүүгийн дэмжлэг 103,284.5 мянган төгрөгөөр дутуу санхүүжигдсэнээс шалтгаалж ЗДТГ-ын халаалтын зардалтай холбоотой үүссэн 13,775.5 мянган төгрөгийн өглөгөөс голлон шалтгаалсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 1,991,051.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 30,467.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	339,508.7	339,508.7	0.0
Хуримтлагдсан үр дүн	1,379,778.1	1,410,245.6	30,467.5
Өмнөх үеийн үр дүн	3,502,689.3	1,379,778.1	-2,122,911.2
Тайлант үеийн үр дүн	-2,122,911.2	30,467.5	2,153,378.7
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	241,296.7	241,296.7	0.0
Дүн	1,960,583.5	1,991,051.0	30,467.5

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл урьд оноос 30,467.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт

Жавхлант сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн “2023 оны тодотгосон төсөв батлах тухай” 11 дүгээр тогтоолоор 384,794.2 мянган төгрөгийн татварын орлого, 37,235.9 мянган төгрөгийн татварын бус орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 409,197.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 3.0 хувиар тасалсан байна.

Хүснэгт 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/				
Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	384,794.2	380,455.9	-4,338.3	98.9
Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	159,686.1	182,907.0	23,220.9	114.5
Үйл ажиллагааны орлого	29,077.8	22,489.9	-6,587.9	77.3
Хөрөнгийн орлого	7,400.0	10,239.3	2,839.3	138.4
Хөрөнгө борлуулсны орлого	6,400.0	882.3	-5,517.7	13.8
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-22,077.8	-22,077.8	0.0	100.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	1,200.0	2,243.1	1,043.1	186.9

Галт зэвсгийн албан татвар	560.0	780.0	220.0	139.3
Малын тоо толгойн албан татвар	148,039.6	125,236.6	-22,803.0	84.6
Улсын тэмдэгтийн хураамж	3,200.0	3,321.7	121.7	103.8
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	2,000.0	588.0	-1,412.0	29.4
Газрын төлбөр	24,183.0	21,733.0	-2,450.0	89.9
Газрын дуудлага худалдаа	11,191.5	18,873.9	7,682.4	168.6
Ойгоос хэрэглээний мод түлээ бэлтгэж ашигласны төлбөр	434.0	263.9	-170.1	60.8
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	0.0	0.0	0.0	
Байгалийн ургамал ашигласны төлбөр	13,500.0	12,975.0	-525.0	96.1
Татварын бус орлого	37,235.9	28,741.8	-8,494.1	77.2
Хүү, торгуулийн орлого	32,000.0	26,636.8	-5,363.2	83.2
Бусад орлого	5,235.9	2,105.0	-3,130.9	40.2
Нийт дүн	422,030.1	409,197.7	-12,832.4	97.0

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого 23,220.9 мянган төгрөгөөр давж биелсэн нь 2023 оны 7 дугаар сараас төрийн албан хаагчдын цалин хөлс нэмэгдсэнээс шалтгаалсан,
- Газрын дуудлага худалдааны орлого 7,682.4 мянган төгрөгөөр давж биелсэн нь үйлчилгээ явуулах газрын дуудлага худалдааны орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Тасарсан орлогууд:

- Хөрөнгө борлуулсны орлого 5,517.7 мянган төгрөгөөр тасарсан нь иргэдийн үл хөдлөх хөрөнгийн борлуулалт буурсан, төлөвлөгөөг үндэслэлгүй хэт өндөр төлөвлөснөөс,
- Малд ногдуулах албан татварын орлого 22,803.0 мянган төгрөгөөр тасарсан нь төлөвлөсөн орлогыг төвлөрүүлэх ажил хангалтгүйгээс,
- Хүү торгуулийн орлого 5,363.2 мянган төгрөгөөр уг орлогын төлөвлөлт өндөр төлөвлөгдсөнөөс шалтгаалсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Сумын ИТХ-ын 2022 оны 24 дугаар тогтоолоор татварын болон татварын бус орлогыг 377,416.6 мянган төгрөгөөр, аймгаас авах санхүүгийн дэмжлэгийг 821,616.5 мянган төгрөгөөр, төсөвт газрын өөрийн орлогыг 500.0 мянган төгрөгөөр, ОНХС-аас олгох орлогын шилжүүлгийг 170,388.3 мянган төгрөгөөр, урьд оны үлдэгдлээс 210,794.9 мянган төгрөгөөр зэрэг нийт орлогыг **1,580,716.3** мянган төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХ-ын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 118 дугаар тогтоолоор аймгийн 2023 оны төсвийг тодотгосонтой холбогдуулан сумын ИТХ-ын 2023 оны 11 дүгээр тогтоолоор дараах өөрчлөлтийг оруулан төсвийн орлого, зарлагыг 260,115.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, тус бүр **1,840,831.9** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

Санхүүжүүлэх эх үүсвэрийн өөрчлөлт:

- Цалин хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогыг 26,608.3 мянган төгрөгөөр,
- Үйл ажиллагааны орлогыг 20,977.8 мянган төгрөгөөр,
- Байгалийн ургамал ашигласны төлбөрийг 5,600.0 мянган төгрөгөөр,
- Хүү торгуулийн орлогыг 2,000.0 мянган төгрөгөөр,
- Бусад орлогыг 2,235.9 мянган төгрөгөөр,
- Хоршоог хөгжүүлэх сангийн эргэн төлөлтөөс санхүүжих эх үүсвэрийг 57,670.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
- Газрын дуудлага худалдааны орлогыг 8,808.5 мянган төгрөгөөр,
- Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийг 4,000.0 мянган төгрөгөөр тус тус бууруулсан,

Төсвийн зарлагын өөрчлөлт:

- ИТХ-ын урсгал зардлыг 14,852.1 мянган төгрөгөөр,
- ЗДТГ-ын урсгал зардлыг 123,705.9 мянган төгрөгөөр,
- ТЗШ-ийн байгууллагуудын тогтмол зардлыг 28,500.0 мянган төгрөгөөр,
- ОНХС-ийн зардлыг 35,387.6 мянган төгрөгөөр,
- ХХС-ийн зардлыг 57,670.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 944,061.0 мянган төгрөгийг аймгийн төсвөөс, 205,775.9 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 210,794.9 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс, 57,670.0 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 422,030.1 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **1,840,831.9** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр 840,776.5 мянган төгрөгийг аймгийн төсвийн санхүүгийн дэмжлэгээс, 205,775.9 мянган төгрөгийг аймгийн ОНХС-ийн санхүүжилтээс, 200,713.5 мянган төгрөгийг оны эхний үлдэгдлээс, 53,828.6 мянган төгрөгийг ХХС-ийн эргэн төлөлтөөс, 431,275.4 мянган төгрөгийг орон нутгийн орлогоос, 500.0 мянган төгрөгийг үйл ажиллагааны орлогоос зэрэг нийт **1,732,869.9** мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,493,073.7** мянган төгрөг буюу **81.1** хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлын зардлыг 21,768.8 мянган төгрөгөөр, байр ашиглахтай холбоотой тогтмол зардлыг 20,675.0 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 213,558.8 мянган төгрөгөөр, ХХС-аас олгох зээлийг 85,000.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалсан байна.

Тайлант онд сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар нийт 17 төсөл, арга хэмжээнд 494,610.4 мянган төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөж, гүйцэтгэлээр 281,051.6 мянган төгрөгийн санхүүжилт олгон, 116,014.8 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь зураг төсөв хийгдээгүй 2 төсөл, арга хэмжээ болон малын тоо толгойн албан татварын орлого 22,803.0 мянган төгрөгөөр тасарч 1 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй зэргээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн ЗДНХ-өөс 4,243.1 мянган төгрөг, аймгийн Статистикийн хэлтсээс 1,473.2 мянган төгрөг, аймгийн БОАЖГ-аас 20,000.0 мянган төгрөг, аймгийн ИТХ-аас 300.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 11,779.3 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 7,659.7 мянган төгрөг зэрэг нийт 45,455.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, урсгал зардалд зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Сумын ОНХС-ын төсвөөс 494,610.4 мянган төгрөгийн 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг боловсруулж, баталсан байна.

Гүйцэтгэлээр харьцуулалтын аргаар гүйцэтгэх 3 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

Хүснэгт 9. Худалдан авах ажиллагаа

/мянган төгрөгөөр/

Хөрөнгө оруулалтын ажлын эх үүсвэр	Нийт төсөл, арга хэмжээ		Үүнээс					
			Шууд худалдан авалт		Харьцуулалтын арга		Нээлттэй тендер шалгаруулалт	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ОНХС	3	179,092.4			3	179,092.4		

Эх сурвалж: www.tender.gov.mn

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жавхлант сумын ТТЗ-ийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал,

дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Анхан шатны баримтын бүрдэлтэй холбоотой зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Анхбаяр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Жавхлант сумын ТТЗ нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01/46 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 1,142,537.7 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу **11,425.4** мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үр дүнгийн тайлангийн нийт зардал болох 1,457,806.6 мянган төгрөгөөс 1.0 хувиар тооцон **14,578.1** мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Жавхлант сумын ТТЗ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- *Батлагдсан төсвийг 18.9 хувиар хэмнэсэн,*
- *ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсан 205,775.9 мянган төгрөгийн ажлаас 110,000,0 мянган төгрөгийн 2 ажил иргэдийн санал авч эрэмбэлээгүй, төсвийн тооцоо судалгаагүй 2 төсөл арга хэмжээг аудитаас өгсөн зөвлөмж, дүгнэлтийг үндэслэн тайлант онд хэрэгжүүлээгүй,*
- *Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,*
- *Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулаагүй,*
- *Албан хаагчдын гар утасны зардал гаргаагүй, сонин хэвлэл захиалаагүй,*
- *Үндэсний баяр наадмаас бусад баяр ёслол, ойн арга хэмжээнд төсвөөс хөрөнгө зарцуулаагүй,*

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.5.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 10. Шилэн данс

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн	Хугацаа хоцроосон	Мэдээлээгүй
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	183	143	40	
2	Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	183	181	2	
3	Засаг даргын Тамгын газар	183	168	15	
	Нийт дүн	549	492	57	

Эх сурвалж: www.shilendans.gov.mn

ТТЗ-ийн түвшинд нийт мэдээлбэл зохих 549 мэдээллээс 492 мэдээллийг хугацаанд нь, **57** мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийг мөрдөж, шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх албан шаардлага өгөх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж үзлээ.

4.6 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.6.1 Завсрын аудитын талаар

Дарга, тэргүүлэх аудиторын 2023 оны 10 дугаар сарын 26-ны 122 дугаар “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2023 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.6.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад 100.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь

Төлбөрийн акт	1	1,145.0	1	1,145.0	100.0
Албан шаардлага	5	46,718.8	4	46,718.8	80.0
Зөвлөмж	3	60,712.7	3	60,712.7	100.0
Нийт дүн	9	108,576.5	8	108,576.5	93.3

Эх сурвалж: Жавхлант сумын ТТЗ-ын 2022 оны аудитын тайлан

Шийдвэрлэлт: Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүйгээс сумын төсвийн орлогын төлөвлөгөөг тасалсан зөрчлийг давтан гаргасан сумын Засаг дарга Ц.Дарханбаатарт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэх.

4.7 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Цаг хугацаа, хүн хүчний хязгаарлагдмал байдлын улмаас ОНХО, ОНХС-ийн эх үүсвэрээр гүйцэтгэгдэж буй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилт, бүртгэл тайлагналтай холбоотой асуудлуудыг бүрэн хэмжээгээр тулган баталгаажуулсан боловч төлөвлөлт, гүйцэтгэл, худалдан авах ажиллагаатай холбоотой асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитад бүрэн хамруулах боломжгүй байлаа.

Иймээс “Улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүн”, “ОНХС-ийн 2023 оны хэрэгжилт, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитаар гүнзгийрүүлэн шалгах шаардлагатай юм.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт **39,989.6** мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс 1,201.0 мянган төгрөгийн төлбөрийн акт, 38,788.6 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

1. Сумын ИТХ-ын дарга, Засаг дарга, засаг даргын орлогч зэрэг улс төрийн албан хаагчдад нийт **1,201.0** мянган төгрөгийн орон нутгийн нэмэгдэл олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутагт ажилласны нэмэгдэл олгох журам”-ын 4 дэх “Орон нутагт ажилласны нэмэгдлийг захиргааны албан тушаал эрхэлдэг орон нутгийн захиргааны байгууллагын төрийн албан хаагчид албан тушаалын сарын үндсэн цалингийн 20 хувиар бодож орон нутгийн болон улсын төсвөөс сар бүр олгоно” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.2 Албан шаардлага

1. Батлагдсан төсвийг зориулалт бусаар, хөтөлбөр, зориулалт, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, бодитоор тайлагнаагүй **7,968.0** мянган төгрөгийн зөрчил илэрсэн байна. Үүнд:

- ИТХ-ын дарга, нарийн бичгийн дарга нарт "Тэргүүний сум"-аар шалгарсан үндэслэлээр цалингийн зардлаас шагналын зардалд 2,097.8 мянган төгрөг,

ЗДТГ:

- Засаг даргад "Тэргүүний сум"-аар шалгарсан үндэслэлээр цалингийн зардлаас шагналын зардалд 1,052.2 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардлаас бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд 588.0 мянган төгрөг,
- Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшууллын зардлаас сумын иргэдэд нэг удаагийн тэтгэмж олгоход 1,000.0 мянган төгрөг,
- Бичиг хэргийн зардлаас ЗДНХ-ийн зардалд 500.0 мянган төгрөг,

ЗДНХ:

- Гадаад томилолтын зардалд 1,890.0 мянган төгрөг,
- Тоног төхөөрөмжийн зардалд 840.0 мянган төгрөг зэрэг.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтууд болон Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Зардлын зориулалт болон арга хэмжээний ангилал", 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай бол төсөвт зохицуулалт хийлгэх албан шаардлага хүргүүлэх.

2. ИТХ нь хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас гүйцэтгэлийн тайлан, үр дүнг тооцсон илтгэх хуудас зэрэг анхан шатны баримтын бүрдэлгүйгээр "Нутгийн удирдлагын холбоо" ТББ-тай хамтран сумын ИТХ-ын 9 төлөөлөгч, ИТХ-ын дарга зэрэг нийт 10 хүнийг БНХАУ-ын Эрээн-Жининь-Хөх хотод зохиогдсон сургалт, туршлага судлах арга хэмжээнд оролцуулан нийт **7,000.0** мянган төгрөгийн үр ашиггүй зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4.1.3 дахь "Үр ашигтай байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

3. Орон нутгийн төсвийн орлогыг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөөгүйгээс орлогын төлөвлөгөөг **12,832.4** мянган төгрөгөөр тасалсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн “... төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална.”, 5.1.2 дахь “Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх”, 41 дүгээр зүйлийн 41.2.1 дэх “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлогын төлөвлөгөөг бодит тооцоо судалгаанд үндэслэн үнэн зөв төлөвлөж, орлогыг бүрэн төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

4. Сумын 2023 оны төсвийн эх үүсвэрт оны эхний үлдэгдлээс санхүүжих дүнг мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдлээс **10,081.4** мянган төгрөгөөр илүү буюу орон нутгийн төсвийн зарлага нь эх үүсвэрээсээ хэтэрсэн, алдагдалтай байдлаар баталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2 дахь “жил бүрийн төсвийн зарлагыг орлого болон санхүүжүүлэх бусад эх үүсвэрээр нь бүрэн нөхдөг байхаар төлөвлөн баталж, хэрэгжүүлэх”, 57 дугаар зүйлийн 57.2 дахь “ Орон нутгийн төсвийг алдагдалгүй төлөвлөн, баталж, хэрэгжүүлнэ”, 57.3 дахь “Орон нутгийн төсвийн урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэх зарлагыг төсөвт тусган баталж хэрэгжүүлэх ба зарлага нь санхүүжүүлэх эх үүсвэрээсээ хэтрэхгүй байна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг үнэн зөв төлөвлөж, баталж байх албан шаардлага хүргүүлэв.

5. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйгээс ИТХ нь 155.0 мянган төгрөгийн НДШ-ийн, ЗДТГ нь 751.8 мянган төгрөгийн байгууллагад төлөх өглөг зэрэг нийт **906.8** мянган төгрөгийн өглөг үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар өглөг үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа	Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан	Буруу тусган илэрхийлсэн	Үүнээс		Зөвлөмж
				Залруулсан	Залруулаагүй	

	Тоо	Дүн										
Дүн												

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Жавхлант ТТЗ	6	39,989.6	1	1,201.0	5	38,788.6						
Дүн	6	39,989.6	1	1,201.0	5	38,788.6						

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 57 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн	1				1			
Дүн	1				1			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	1				1			